

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХАГАС ЖИЛИЙН**

**ТАЙЛАН 2021**

## АГУУЛГА

---

- 03-05** КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА  
Бидний үнэ цэнэ  
Бүтэц зохион байгуулалт
- 06-10** БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
Онцлох үйл явдлууд  
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
Шинэ коллекциуд
- 11-16** САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд  
Санхүүгийн тайлан  
Их хэмжээний хэлцэл  
Сонирхлын зөрчилтэй хэлцэл  
Санхүүжилтийн мэдээлэл  
Компанийн удирдлагын зардал
- 17-18** ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА  
Хувьцааны арилжаа  
Ногдол ашиг
- 19-28** КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ  
Засаглалын тогтолцоо  
Хувьцаа эзэмшигчид  
Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Төлөөлөн удирдах зөвлөл  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн  
Эрх бүхий албан тушаалтнууд  
Тогтвортой хөгжил

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь Хувьцаат Компани
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Компанийн албан ёсны хаяг	Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утас: (976)-70139977  Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere  Онлайн дэлгүүр: <a href="http://www.gobicashmere.com/de/">www.gobicashmere.com/de/</a> <a href="http://www.gobicashmere.com/uk/">www.gobicashmere.com/uk/</a> <a href="http://www.gobicashmere.com/fr/">www.gobicashmere.com/fr/</a> <a href="http://www.gobicashmere.com/ru/">www.gobicashmere.com/ru/</a> <a href="http://www.gobicashmere.com/pl/">www.gobicashmere.com/pl/</a> <a href="http://www.gobicashmere.com">www.gobicashmere.com</a> <a href="http://www.gobicashmere.com/us/">www.gobicashmere.com/us/</a> gobi.tmall.com gobicashmere.taobao.com mall.jd.com/index-10266660.html?from=pc Wechat: 戈壁羊绒
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9 сарын 5-ны өдөр
Ажилтнуудын тоо	1,523
Хүчин чадал	1,150 тонн түүхий ноолуур боловсруулах 1,050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас ээрэх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх
Дэлгүүрийн тоо	Дотоод Улаанбаатар хот 2 Дархан хот 1  Гадаад Охин компани 3 Салбар дэлгүүр 1 Франчайз дэлгүүр 27 Онлайн дэлгүүр 11

## БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

---

### ХҮНИЙ НӨӨЦ

Бидний гол нөөц болох ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлага нь хүний нөөцийн хөгжлөөр нэмүү өртөг үүсгэх гол боломж болно

### ОЮУНЫ НӨӨЦ

Бидний ирээдүйн орлогын баталгаа, өрсөлдөх хүч болсон оюуны өмч, брэнд болон нэр хүнд

### БАЙГАЛИЙН НӨӨЦ

Бидний ирээдүйн сайн сайхны үр үндэс болох байгалийн нөөц баялаг (түүхий ноолуур, ус, агаар, хөрс, бүтээгдэхүүн зэргийн эрүүл байдал)

### САНХҮҮГИЙН НӨӨЦ

Хувьцаа эзэмшигчид, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага болон үйл ажиллагаанаас эх үүсвэртэй шаардлагатай санхүүжилт (зээл, баталгаа...)

### ҮЙЛДВЭРИЙН НӨӨЦ

Говь ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн зориулалт бүхий биет материал болон хөрөнгө

### НИЙГЭМ ХАРИЛЦААНЫ НӨӨЦ

Говь ХК болон бусад бүх оролцогч талуудтай үүсэх харилцаа нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын баталгаа болно

## БИДНИЙ ЗОРИЛТ

---

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнтэй байгууллага байна

**УРИА:** Ноолууран хувцсыг хүн бүрд

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** Загварлаг, чанартай, нийцэмжит үнэтэй ноолууран хувцсаа дэлхийд таниулж, хүн бүрийг гоёно

**АЛСЫН ХАРАА:** Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна






## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2021 оны 4 сарын 24-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2 дахь жилдээ цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Хуралд нийт 689,739,647 саналын эрхтэй 136 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 88.42% байв.



#### "ГОВЬ" ХК-ИЙГ "ТОП-100" АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭГЭЭР ӨРГӨМЖИЛЛӨӨ

2021 оны 6 сарын 28-ний өдөр Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" Аж Ахуйн Нэгжийг шалгаруулах цахим арга хэмжээ болж, "Говь" ХК нь 31 дүгээр байранд шалгарлаа.



#### АЖИЛТАН БҮРИЙГ ХУВЬЦААГААР УРАМШУУЛАХ ХӨТӨЛБӨР

2021 оны 6 сарын 29-ний өдөр Монголын Хөрөнгийн Бирж дээр "Цан Цохих" арга хэмжээг зохион байгуулж "Говь" ХК 1,500 ажилтнаа хувьцаагаар урамшуулах хөтөлбөрийг албан ёсоор зарлаж, "Таван Богд Капитал" ҮЦК-тай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Говь ХК-ийн 1,500 ажилтан хөрөнгө оруулагч ажилтан боллоо.



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нар “Үйлдвэр болон ажилтнуудын орон сууц барих хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

**Ogilvy**

## МАРКЕТИНГИЙН АГЕНТ ЧИГЛЭЛЭЭР ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ “OGILVY” КОМПАНИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Олон улсын брэндийн стратеги, дижитал маркетинг чиглэлээр олон улсын тэргүүлэх “Ogilvy” компанитай 2 дахь жилдээ амжилттай хамтран ажиллаж байна.



## ГОВЬ БРЭНД ДЭЛХИЙН АЛДАРТ VOGUE UK СЭТГҮҮЛИЙН ХУУДАСНАА

Дэлхийн загварын хамгийн том сэтгүүл болох Английн VOGUE сэтгүүлийн 2021 оны 3 дугаар сарын дугаар дижитал болон хэвлэмэл байдлаар худалдаанд гарсан бөгөөд, хувцас загварын буланд Говь брэндийн ноолууран пальто, хоёр талт пальто болон бусад бүтээгдэхүүнийг онцоллоо.

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

---

### ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

Хэрэглэгчдэд хоёр талт пальтог илүү сонголттой болгох зорилгоор жин хөнгөрүүлсэн драп шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. SS2021 Riviera Chic коллекцид зориулан богино загварын пальтог энэхүү жин хөнгөн тансаг драпаараа худалдаанд гаргалаа.





## ШИНЭ КОЛЛЕКЦИУД


### ҮНДСЭН КОЛЛЕКЦ



ГОВЬ ХАВАР/ЗУН 2021, "ICE CREAM" COLLECTION




ГОВЬ ХАВАР/ЗУН 2021, "RIVIERA CHIC" COLLECTION



ГОВЬ ХАВАР/ЗУН 2021, "TERRACOTTA" COLLECTION



ГОВЬ ХАВАР/ЗУН 2021, "PALM LEAF" COLLECTION



YAMA PRE-SPRING 2021, "BACK TO RETRO" COLLECTION

НЭМЭЛТ КОЛЛЕКЦ



GOBI "COAT" COLLECTION 2021



"TRENCH COAT" COLLECTION  
ШИНЭ ӨНГӨ



ХАТГАМАЛТАЙ ПИДЖАК  
ШИНЭ ӨНГӨ



ЭРЭГТЭЙ БАР ШААЛЬ  
"ШАТАР"



ЭМЭГТЭЙ БАР ШААЛЬ  
"УЛААНБААТАР"

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2020.06.30 гүйцэтгэл	2021.06.30 гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
				өөрчлөлт	хувь
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>	<i>сая.төг</i>	37,462	39,608	2,147	6%
Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	18,808	17,436	(1,372)	-7%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	14,649	9,639	(5,010)	-34%
Охин борлуулалт	<i>сая.төг</i>	4,005	12,534	8,529	213%
<b>БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ</b>	<i>сая.төг</i>	25,150	21,839	(3,311)	-13%
<b>НИЙТ АШИГ</b>	<i>сая.төг</i>	12,312	17,770	5,457	44%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	32,854	39,317	6,463	20%
Үйл ажиллагааны бус зардал	<i>сая.төг</i>	1,987	(936)	(2,924)	-147%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(22,530)	(20,611)	1,919	9%
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<i>сая.төг</i>	(21,397)	(19,679)	1,718	8%
<b>ҮЙЛДВЭРЛЭЛТ</b>					
Сүлжмэл	<i>ширхэг</i>	490,780	125,931	(364,849)	-74%
Нэхмэл	<i>метр</i>	103,621	23,670	(79,951)	-77%
Оёмол	<i>ширхэг</i>	26,511	11,176	(15,335)	-58%
Ээрмэл	<i>тонн</i>	126,926	58,180	(68,746)	-54%
<b>ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ</b>					
Ноолуур	<i>тонн</i>	655	-	(655)	-100%
<b>АЖИЛТНУУДЫН ТОО</b>	<i>хүн</i>	2,054	1,523	(531)	-26%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	18,239	26,007	7,768	43%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<i>сая.төг</i>	1,881	4,149	2,268	121%

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 6 сарын 30  
(мян. төг)

	2020.12.31	2021.06.30
<b>ХӨРӨНГӨ</b>		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,798,745	60,490,736
Дансны ба бусад авлага	5,996,260	6,741,169
Урьдчилгаа төлбөр	3,000,896	3,553,030
Бараа материал	193,207,689	182,672,977
Орлогын албан татварын авлага	265,286	203,929
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	646,063	220,140
	<u>215,914,938</u>	<u>253,881,982</u>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	156,243,324	150,866,447
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,631,104	2,107,023
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,073,481	5,064,944
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	950,981	894,311
	<u>163,898,890</u>	<u>158,932,725</u>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b><u>379,813,828</u></b>	<b><u>412,814,706</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны ба бусад өглөг	21,934,076	17,665,220
Гэрээний өр төлбөр	1,541,384	2,249,011
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	1,010,634	338,677
Орлогын албан татварын өглөг	46,241	61,049
Богино хугацаат түрээсийн өглөг	1,001,198	1,029,658
Богино хугацаат банкны зээл	267,714,096	324,547,842
	<u>293,247,630</u>	<u>345,891,457</u>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат түрээсийн өглөг	1,900,851	1,384,540
Урт хугацаат банкны зээл	4,458,498	4,458,498
Урт хугацаат өглөг	14,955,172	14,955,014
	<u>21,314,521</u>	<u>20,798,052</u>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b><u>314,562,151</u></b>	<b><u>366,689,509</u></b>
<i>Эзэмшигчдийн өмч</i>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	48,974,836	48,974,836
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(1,362,032)	(809,078)
<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b><u>16,858,760</u></b>	<b><u>(2,820,675)</u></b>
	<u>65,251,677</u>	<u>46,125,197</u>
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b><u>379,813,828</u></b>	<b><u>412,814,706</u></b>



## НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2021 оны 6 сарын 30  
(мян. төг)

	2020.12.31	2021.06.30
<b>Борлуулалтын орлого</b>	<b>117,092,505</b>	<b>39,608,470</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(71,536,490)	(21,838,881)
<b>Нийт ашиг</b>	<b>45,556,015</b>	<b>17,769,589</b>
Санхүүгийн ба бусад орлого	2,615,647	391,702
Бусад олз ба (гарз)	(8,480,653)	645,687
Хүүгийн зардал	(29,542,260)	(12,450,497)
Борлуулалт ба маркетингийн зардал	(44,384,939)	(19,672,424)
Ерөнхий ба удирдлагын зардал	(13,076,638)	(7,294,975)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	(170,306)	0
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>(47,483,133)</b>	<b>(20,610,918)</b>
Орлогын татварын зардал	1,327,791	931,483
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>	<b>(46,155,342)</b>	<b>(19,679,435)</b>
<b>Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:</b>		
Гадаад дахь охин компанийн цэвэр хөрөнгийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,083,503)	552,954
<b>Бусад дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>(1,083,503)</b>	<b>552,954</b>
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>(47,238,844)</b>	<b>(19,126,481)</b>

## НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 6 сарын 30  
(мян. төг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
<b>2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>15,647,697</b>	<b>(278,530)</b>	<b>63,014,101</b>	<b>79,163,382</b>
Тайлант жилийн цэвэр ашиг				(46,155,342)	(46,155,342)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		33,327,139	(1,083,503)		32,243,637
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		33,327,139	(1,083,503)	(46,155,342)	(13,911,705)
Зарласан ногдол ашиг					
<b>2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>48,974,836</b>	<b>(1,362,032)</b>	<b>16,858,760</b>	<b>65,251,677</b>
Тайлант жилийн цэвэр ашиг				(19,679,435)	(19,679,435)
Бусад дэлгэрэнгүй алдагдал			552,954		552,954
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	-	552,954	(19,679,435)	(19,126,481)
Зарласан ногдол ашиг					
<b>2021 оны 06 сарын 30-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>48,974,836</b>	<b>(809,078)</b>	<b>(2,820,675)</b>	<b>46,125,197</b>

## НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 6 сарын 30  
(мян. төг)

	2020.12.31	2021.06.30
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(30,565,123)	(8,011,786)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(6,250,007)	(4,149,072)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	38,585,512	60,707,430
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,770,382	48,546,572
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	386,619	(854,580)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10,641,744</b>	<b>12,798,745</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>12,798,745</b>	<b>60,490,736</b>

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн болно.

(мян.төг)

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2020.06.30	2021.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	12,459,400	
Холбоотой талаас авсан санхүүжилт	12,459,400	
Холбоотой талтай хийсэн борлуулалт	37,171	16,089
Холбоотой талаас авсан худалдан авалт	564,651	415,303
Хүүгийн орлого	-	
Хүүгийн зардал	1,329,248	1,016,709
Түрээсийн орлого	119,795	99,213
Түрээсийн зардал	438,164	260,499

## САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

БАНКНЫ НЭР	2020.12.31	2021.06.30
Хаан банк	8,000,000	7,000,000
Худалдаа Хөгжлийн Банк	4,458,498	4,458,498
Голомт банк	26,000,000	52,500,000
Худалдаа Хөгжлийн Банк (зээлийн шугам)	-	26,200,000
Монгол Улсын Хөгжлийн Банк	82,900,000	82,900,000
Хас Банк	5,000,000	15,000,000
ADB/TDB	3,960,000	2,970,000
EBRD	34,712,213	34,711,847
IIB	104,873,400	101,824,800
НИЙТ (төгрөг)	269,904,110	327,565,145

## КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ


(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2020.06.30	2021.06.30
ТУЗ-ийн цалин урамшуулал	79,200	67,200
Удирдлагын цалин урамшуулал	398,078	524,436
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	13,921	15,957
НИЙТ	491,199	607,594



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



## ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ҮЗҮҮЛЭЛТ	2021.06.30	Өсөлт, бууралт /%/		2020.12.31	2020.06.30
		2020.12.31- нээс	2020.06.30- наас		
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО (шир)	780,112,500			780,112,500	780,112,500
Төрөл	энгийн хувьцаа			энгийн хувьцаа	энгийн хувьцаа
ХУВЬЦААНЫ ҮНЭ (төг)*					
Хаалтын үнэ	249.96	25.9% ↑	24.7% ↑	192.5	195
Хамгийн их үнэ	249.96	15.45% ↓	15.45% ↓	291.86	291.86
Хамгийн бага үнэ	193.01	15.7% ↑	15.64% ↑	164.85	164.85
Дундаж үнэ	232.57	12.3% ↑	6.69% ↑	206	217.9
АРИЛЖААЛАГДСАН ТОО (шир)	6,466,477	51.6% ↑	98.6% ↑	3,811,314	2,195,830
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН (мян. төг)	1,503,380	63.35% ↑	105.4% ↑	780,044	465,466
<b>КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (мян. төг)</b>	<b>194,996,920</b>	<b>25.9% ↑</b>	<b>24.7% ↑</b>	<b>150,171,656</b>	<b>152,121,937</b>

## НОГДОЛ АШИГ

## НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (мян. төг)	Ногдол ашиг тараалт
1996	61	475,869	Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	154	1,199,813	
1998	150	1,170,169	
1999	166	1,294,987	
2000	100	780,113	
2001	20	157,271	
2005	60	468,068	
2006	60	468,068	
2010	100	780,113	ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан.
2011	100	780,113	
2012	125	975,141	
2013	130	1,014,146	
2014	140	1,092,158	
2015	140	1,092,158	
2016	200	1,560,225	
2017	220	1,716,247	
2018	6.8	5,304,765	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс тарааж эхэлсэн.
2019	-	-	ТУЗ-ийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаагүй болно.
2020	-	-	ТУЗ-ийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 05 тоот тогтоолын дагуу 2020 онд ногдол ашиг хуваарилахгүй болно.


## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	392,745,306	50.34%
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

**780,112,500**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО

**19,010**

/2021.06.30-ны байдлаар/

- ХИДЕ ИНТЕР ХХК Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. /Япон улс/
- ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь "Таван Богд Групп"-ийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

### ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 11:00 цагт Говь ХК-ийн оффис дээрээс зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал, COVID 19-тэй холбоотой хөл хорионы улмаас Говь ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хоёр дахь жилдээ цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан бөгөөд "Gobi Cashmere" албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан шууд дамжуулалтыг хүргэсэн билээ. Хуралд 88.42 хувийн саналын эрхтэй нийт 136 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд дараах асуудлыг хэлэлцэж батлав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн "Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан" гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

---

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлдгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

#### *Эрсдэл, аудитын хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн үр чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### *Нэр дэвшүүлэх хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

#### *Цалин, урамшууллын хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХАРААТ БУС ГИШҮҮД

---



**Дамбын  
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга  
Хараат бус гишүүн

/Цалин  
урамшууллын  
хорооны дарга, Нэр  
дэвшүүлэх хорооны  
гишүүн/

**СЭЗИС, Бизнес  
удирдлагын  
тэнхимийн  
профессор**



**Мягмарын  
БАЯР**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Нэр дэвшүүлэх  
хорооны дарга/

**ШУТИС-ийн ҮТС-ийн  
Хөнгөн  
үйлдвэрлэлийн  
технологи  
инженерчлэлийн  
салбарын дэд  
профессор**



**Банзрагчийн  
НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны дарга/

**СЭЗИС, Бизнесийн  
Удирдлагын  
тэнхимийн ахлах  
багш**



**Такэши  
КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Цалин урамшууллын  
хорооны гишүүн/

**Asahi Life Insurance  
Менежер**



**Алтангэрэлийн  
ЖАРГАЛМАА**

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн/

**Гаге, АССА ахлах  
багш, хөтөлбөрийн  
удирдагч**

ЕРДИЙН ГИШҮҮД

---



**Цагаачийн  
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

/Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн/

**Таван Богд  
Группийн  
Ерөнхийлөгч,  
Говь ХК-ийн  
Гүйцэтгэх захирал**



**Дашдаваагийн  
ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн/

**Таван Богд  
Группийн Тэргүүн  
дэд ерөнхийлөгч**



**Хидэо  
САВАДА**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

**Н.И.С компанийн  
Ерөнхийлөгч**



**Жавзандолгорын  
ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

/Цалин урамшууллын  
хорооны гишүүн/

**Таван Богд Групп,  
Маркетингийн  
газрын захирал**



## КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

---



Цагаачийн  
БААТАРСАЙХАН

Гүйцэтгэх захирал



Чулуунбатын  
СОЛОНГО

Тэргүүн дэд захирал



Отгонтөгсийн  
МИШЭЭЛ

Дэд захирал




Ганболдын  
СЭЛЭНГЭ

Санхүү хариуцсан  
захирал



Энхбаярын  
ТОД-ОД

Санхүү, стратеги  
төлөвлөлт  
хариуцсан захирал




Найдангийн  
ТЭГШЖАРГАЛ

Хүний нөөц,  
захиргаа хариуцсан  
захирал



Эрдэнэбилэгийн  
УРТНАСАН

Мэдээлэл технологи  
хариуцсан захирал



Батчулууны  
АРИУНАА

Борлуулалт  
хариуцсан захирал



Энхдалайгийн  
МИШЭЭЛ

Онлайн борлуулалт  
хариуцсан захирал  
/Хятад/




Даваанямын  
НАНДИНБАЯР

Онлайн борлуулалт  
хариуцсан захирал  
/Европ/



**Чулуунбатын  
ҮНЭНБАТ**

Онлайн борлуулалт  
хариуцсан захирал  
/Америк/



**Батсуурийн  
БОЛОРМАА**

Дизайн хөгжүүлэлт  
хариуцсан захирал



**Эрдэнэцэцэгийн  
ЗОЛЗАЯА**

Үйлдвэр удирдлага  
хариуцсан захирал



**Цогтбаярын  
ЦАСЧИХЭР**

Хуулийн хэлтсийн  
дарга



**Батпүрэвийн  
НАРАНТУЯА**

ТУЗ-ийн нарийн  
бичгийн дарга

**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ**

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 50.34%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
НИЙТ	51.92%	

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

"Говь" ХК нь ноос ноолуурын салбарын тэргүүлэгч компанийн хувьд салбарын болоод улс орныхоо эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахыг эрхэмлэн ажилладаг. Бид хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг ямагт тооцоолж, түүнээс сэргийлэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, малчид болон орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлчээрийн зөв зохистой ашиглалтыг дэмжин ажиллаж, байгальд ээлтэй техник технологийг эрэлхийлэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нөөцийн зүй зохистой хэрэглээг хэвшүүлэхийг зорьдог. Энэхүү зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны үе шат бүртээ тогтвортой хөгжлийн түлхүүр болсон үзүүлэлтүүдийг орхигдуулалгүй уялдуулан, хэвшүүлж чадсанаар эрүүл эргэх холбоог цогцлоож чадах бөгөөд манай компанийн бизнесийн үйл ажиллагаа урт хугацаандаа улам бүр батжин, улс орныхоо ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болох болно.

### "ГОВЬ" ХК ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЛЭЭС "МӨНГӨН БАТЛАМЖ" ХҮРТЛЭЭ



"Говь" ХК нь SFA/Тогтвортой ноос ноолуурын олон улсын эвслээс олгодог "Тогтвортой арга аргачлалаар цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал" буюу C003 стандартын "МӨНГӨН БАТЛАМЖ" гардан авлаа.

C003 стандартын дагуу түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөр аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй стандартын шалгуурт нийцүүлэн тогтвортой арга зарчмыг баримтлан ажилладаг бидний үйл ажиллагааг баталгаажуулан гэрчилж байна.

## “ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ”-Д НЭГДЭВ



2021 онд Текстилийн Салбарын Тогтвортой Үйлдвэрлэл Ба Эко Тэмдэг Төсөл /STEEPCOLAB/, Монголын Ноос Ноолуурын Холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм”-ийг боловсруулан гаргасан.

Бид Монголын текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрмийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, байгальд ээлтэй, нийгмийн харилцаатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлэн уг дүрэмд нэгдлээ.

## “ТОГТВОРТОЙ НОЛУУР, ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ”



“ГОВЬ” ХК Үйлдвэрлэл - Шинжлэх ухаан - Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, улмаар үржлийн шилмэл хээлтүүлэгчийг үржил селекцийн ажилд ашиглах болон малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий **“Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”**-ийг 2020 оноос эхлэн ХААИС-ийн эрдэмтэн багш нар болон малчидтай хамтран хэрэгжүүлж байна.

2021 онд төсөл хэрэгжиж байгаа Хөвсгөл болон Баянхонгор аймгаас ирсэн ямааны ноолуурын нийт 420 дээжид ширхэгтийн шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээг хийж, төсөл амжилттай үргэлжилсээр байна.

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

“ГОВЬ” ХК, ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,  
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434  
УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081  
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN